



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№12 /226/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.14

Цаг үе, үйл явдал

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын 2022 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр гаргасан Коронавируст халдвар (ковид-19)-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай албан бичгийг бүрэн эхээр нь хүргэж байна.

Монгол Улсын хэмжээнд коронавируст халдвар (ковид-19)-ын "Омикрон" хувилбар илэрч, тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан халдвар хамгааллын дэглэм сахиулах, урьдчилан сэргийлэх, алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, цэргийн алба, өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулах, эрүүл мэндийн байгууллагуудын ачааллыг нэмэгдүүлэхгүй байх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллагууд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, салбарын дарга, командлагч, захирагч нарт даалгаж байна. Үүнд:

1. Батлан хамгаалах яамны "Шуурхай удирдлагын бүлэг", Зэвсэгт хүчний Жанжин штабын "Шуурхай удирдлагын штаб"-ын үйл ажиллагааг эрчимжүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтөд тодотгол хийж, шаардлагатай удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
 2. Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам болон мэргэжлийн байгууллагуудаас гаргасан тогтоол, тушаал, зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллах;
 3. Цар тахлын халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, нөхцөл байдлын бодит мэдээллээр хангах;
 4. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн сүлжээгээр аливаа мэдээлэл нийтлэхгүй, түгээхгүй байхад онцгойлон анхаарах;
 5. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад онцгой анхаарал хандуулж, дархлаажуулалтыг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
 6. Нэгтгэл, анги, байгууллагын "Тусгаарлах байр"-ын бэлэн байдлыг хангаж, эм, эмнэлгийн хэрэгслийн шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;
 7. Нэгдсэн арга хэмжээ, хурал, зөвлөгөөн, сургалтын үйл ажиллагааг Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам болон Батлан хамгаалах яамнаас гаргасан шийдвэр, зөвлөмжийн хүрээнд хязгаартай /цахим хэлбэр/-гаар зохион байгуулах;
 8. Байгууллагуудад гаднаас нэвтрэх иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах, нэн шаардлагатай тохиолдолд халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахиулан нэвтрүүлж байх;
 9. Цэргийн төв эмнэлгийн ачааллыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарч, алба хаагчийг шаардлагатай тохиолдолд хэвтэн эмчлүүлэх арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулах;
 10. Хүний эрх, ялангуяа хөдөлмөрлөх эрх болон жендерт суурилсан ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, шахалт, хүчирхийлэл, хүнлэг бус байдлаар хүний нэр хүндийг доромжлон харьцах, дам үгээр шийтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад анхаарах;
 11. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах, ажил таслалт, хийдэл гаргуулахгүй байх, сахилгын хариуцлагыг бүх түвшинд чангатгах талаар нийт бие бүрэлдэхүүнд үүрэг чиглэл өгч ажиллах зэрэг болно.
- Албан даалгаврын хэрэгжилтийн талаар 7 хоног бүрийн Баасан гарагт Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчид танилцуулж байхыг Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгож байна.

"ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ЦЭРГИЙН ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ" БАТЛАГДЛАА



Батлан хамгаалах хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалт боловсронгуй болж, дагаж мөрдөх журмууд шинэчлэгдэх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зарлигаар "Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журам" батлагдан гарлаа.

Өнгөрсөн оны 8 дугаар сард Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо нараар ахлуулсан "Цэргийн цол олгох журам"-ыг шинэчлэх ажлын хэсэг томилогдон, цэргийн цол олгох асуудлыг цэгцлэх, цэргийн цолны үнэлэмж, зохистой харьцааг зохицуулах, цэргийнхний нэр хүндийг өсгөх, цэргийн алба хаагчдын албандаа итгэх итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх, алба хаагчдын өөрийгөө хөгжүүлэх, боловсруулах хөшүүрэг болох зорилгоор уг журмыг шинэчлэх ажлыг хийсэн билээ.

Ерөнхийлөгчийн энэхүү шийдвэр нь ЗэвсэгтхүчнийЕрөнхийкомандлагчийнхувьд цэргийн цол хэрэглэдэг байгууллагуудын эрх зүйн асуудлаар гаргасан анхны шийдвэр төдийгүй түүний баримталдаг нийгэмд шударга ёс тогтоох талаар авч хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээ бөгөөд шинэ журамд бэлтгэл үүрэгтний цолыг хавтгайруулан олгодог тогтолцоог халсан, ахлах болон дээд офицеруудад тавигдах боловсролын шаардлага өндөрсөн, цэргийн цолны нийтлэг стандарттай болсон зэрэг зарчмын өөрчлөлтүүдээс гадна цэргийн сургуульд сурч байгаа алба хаагчдад хугацааны цолыг нь олгодог, эдэлж байгаа цолноосоо нэгээс дээш цолны зэрэглэл бүхий тушаалд томилогдвол дараагийн цолыг цол хоорондын хугацааны 50-иас дээш хувийг эдэлсэн бол олгож болох зэрэг хүмүүнлэгийн гэмээр заалтууд оржээ.

ҮНДСЭН ХУУЛИАР ЯРИА ТАНИУЛГА ХИЙВ



Зэвсэгт хүчний 336 дугаар анги
Шинэ Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан хугацаат цэргийн алба хаагчдад чиглэсэн хэд хэдэн арга хэмжээг зохион байгууллаа. Тухайлбал, Монгол Улсад анхдугаар Үндсэн хууль батлагдсанаас хойш шинэ ардчилсан Үндсэн хууль батлагдах хүртэлх түүхэн замналын талаар видео хичээл үзүүлж, "АХА" тэмцээнийг явуулав. Мөн "Үндсэн хууль ба хүний эрх" сэдвээр яриа таниулга хийж, тэргүүлсэн хугацаат албаны дайчдаа шагнаж урамшууллаа.

Ахлах дэслэгч Ч.БОДЬГЭРЭЛ

Түүхэнд энэ өдөр

1966 он он.

БНМАУ-ын ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд "Найрамдал, нөхөрлөл, харилцан туслах тухай" гэрээ байгуулав.

1998 он он.

Батлан хамгаалахын сайдын 16/12 дугаар тушаалаар "Баянмонгол" чуулгын Бүх Цэргийн дуу бүжгийн чуулгын бүрэлдэхүүнд шилжүүлэв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-14	-33

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.00	2,854.0
EUR	3,260.0	3,270.0
CNY	448.30	449.00
RUB	38.80	39.50
JPY	24.65	24.80
KRW	2.39	2.41

ЗУРХАЙ

2022.01.14 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 12/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.38-17.25

БАРИЛДЛАГА:

Шид

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Өтлөх үхэхүй

Суудал: Огторгуй

Энэ өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэв дэвших, гарагийг тахиx, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2.267.296 /69.7%/	2,166.817 /66.6%/	946.536 29,1%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
7476 +112	191	7169

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 320,857,480

Эдгэрсэн

Нийт: 264,014,557

Нас барсан

Нийт: 5,538,769

ЦЭРЭГЖЛИЙН СПОРТЫН ӨВЛИЙН 2 ТӨРӨЛТИЙН ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Агаарын цэргийн командлалын нэрэмжит Зэвсэгт хүчний аварга шалгаруулах Цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлт, ЦСЦ-ын өвлийн олон төрөлтийн тэмцээн Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төвд амжилттай үргэлжилж байна.

Цэрэг спортын өвлийн тэмцээн уралдаан нь цэргийн алба хаагчдын өвлийн сургалт бэлтгэл, байлдааны бэлтгэлийн үндсэн суурь болж өгдөг. Ингэснээр цэргийн алба хаагчдаа бэлтгэх, сургах, дадлагуулах нэг том хэлбэр юм. Хэдий цар тахлаас шалтгаалан сургалт бэлтгэл хязгаарлагдмал хүрээнд явагдаж байгаа ч цэргийн бэлтгэл сургалт тасрах ёсгүй юм. Тиймдээ ч энэ удаагийн цэрэгжлийн спортын өвлийн тэмцээнүүдэд оролцож байгаа цэргийн алба хаагчдын бэлтгэл алдагдаагүйн дээр орлогчдын бэлтгэл сайн

байгааг энэ үеэр Ерөнхий шүүгч хурандаа Д.Цог-Эрдэнэ хэлж байлаа. Мөн тэрээр цааш нь хэлэхдээ яг тухайн цаг мөчид зохион байгуулагдаж байсан цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлтийн тэмцээнүүдийн талаар "Патураль бол цэрэг хүний өдөр тутмын албаны онцлогт тохирсон багийн спорт. Эл спорт нь Финланд Улсаас гаралтай бөгөөд цэрэг дайчдыг улам чадварлаг болгох үүднээс өвлийн улиралд зохион байгуулж эхэлснээс улбаатай юм. Манай улсын хувьд тус тэмцээн орхигдсон хэдий ч Зэвсэгт хүчин авч үлдэж буйн зэрэгцээ уламжлал болгон зохион байгуулсаар байна.

Харин дэлхийн хэмжээнд биатлоны төрөл ихээхэн хөгжиж байгаа спортын нэг бөгөөд манай улсын хувьд биатлоны холбоо олон тамирчныг бэлтгэж байгаа" гэв. Дээрх



цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлт нь цэрэгжлийн спортын энэ олон төрлийн тэмцээнүүд нь Зэвсэгт хүчний 2021-2022 оны биеийн тамир, спортын уралдаан тэмцээнийг нээж байгаа тус тэмцээний Цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлт болон биатлон, патурлын шилдгүүд өчигдөр тодорсон юм.

Үүнд, Зэвсэгт хүчний 2022 оны аварга шалгаруулах "Өвлийн 2 төрөлт"-ийн биатлонд хувийн дүнгээр 1 дүгээр байртай ахлагч О.Гантулга /337/, 2 дугаар байрт дэслэгч У.Батжаргал /015/, 3 байрт ахлагч Ө.Отгонбаяр /350/ тус тус шалгарлаа. Биатлоны багийн дүнгээр 1 дүгээр байрт ахмад Б.Цээноров, ахлагч

Ө.Отгонбаяр /350/, 2 дугаар байрт ахлагч Б.Мөнх-Эрдэнэ, Ц.Ганзориг /084/, 3 дугаар байрт ахлагч О.Гантулга, дэд ахлагч Б.Ганхүү /337/ нар тус тус шалгарсан юм.

Харин өчигдөр зохион байгуулагдсан Патрулын төрөлд 1 дүгээр байрт ахмад Т.Баатархүү, ахлах ахлагч Б.Батжаргал, ахлагч Б.Мөнх-Эрдэнэ, Ц.Ганзориг /084/, 2 дугаар байрт ахмад Б.Цээноров, ахлагч Ө.Отгонбаяр, Т.Гантулга, дэд ахлагч Д.Энхтайван /350/, 3 дугаар байрт хошууч Б.Хэнзээ, дэслэгч У.Батжаргал, ахлах ахлагч Р.Ганхуяг, ахлагч Батмөнх /015/ тус тус шалгарав. Ийнхүү зургаа дахь өдрөө зохион байгуулагдсанаар цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлтийн тэмцээн өндөрлөж байгууллагын дүнгээр нэгдүгээр байрыг хурандаа Д.Шинэбаяр захирагчтай

Зэвсэгт хүчний 084, 2 дугаар байрыг хурандаа Ж.Сүх-Очир захирагчтай Зэвсэгт хүчний 350, 3 дугаар байрыг дэд хурандаа Б.Олзбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 150 дугаар ангиуд эзэллээ.

Аливаа уралдаан тэмцээний бэлтгэл гэдэг тухайн тэмцээний үр дүнг илтгэн харуулдаг. Энэ ч үүднээс тус тэмцээний бэлтгэлд эрт гарсан, өөрсдийн нэгтгэл, ангийн байрлалд зам засаж бэлтгэлээ хийсэн ангиуд өөр байгаа талаар олон хүн дурдаж байлаа. Түүнчлэн тус тэмцээнд Зэвсэгт хүчний 339 дүгээр анги анх удаа оролцож байгаа аж.

Өнөөдрөөс эхлэн ахмадын аварга шалгаруулах тэмцээн болон ЦСЦ-ын өвлийн олон төрөлтийн тэмцээнүүд эхэлж байгаа юм. Тэмцээн ирэх Ням гарагт өндөрлөнө.



Цахим шууданд

СҮХБААТАР АЙМГИЙН УГСААТНЫ ЗҮЙН МУЗЕЙН АЖИЛТНУУД МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙД



Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музейн маркетинг хариуцсан мэргэжилтэн Ц.Эрдэнэбулган, эрдэм шинжилгээний ажилтан О.Ариунжаргал нар өчигдөр Монгол цэргийн музейд ажиллаж музейн ажлын туршлага судалж, арга зүйн зөвлөмж авлаа.

Уг ажлын хүрээнд, музейн бүртгэл мэдээллийн санд хөтлөгддөг бүх баримт бичгийг зааврын дагуу хөтлөх, үзмэрийн эрдэм

шинжилгээний карт, тодорхойлолт бичих арга зүй, үзмэрийн хувийн хэрэг хөтлөлт, үзүүлэг дэглэлтэд сүүлийн үеийн шинэлэг шийдлийг ашигласан байдал, музейн үзүүлэгт шинэ техник, технологи нэвтрүүлсэн туршлага /Холограмм, мэдрэгчтэй дэлгэц бусад төхөөрөмж/, үзмэрийн хаяг тайлбарын мэдээлэл боловсруулах зэрэг сэдвийн хүрээнд хамтран ажиллав. Түүнчлэн

хүүхдэд зориулсан хаяг тайлбарыг яаж боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд музейн үйлчилгээг хэрхэн хүртээмжтэй байдлаар хүргэсэн талаар туршлага судалж, зөвлөмж авах, музейгээс үзэгчдэд хүргэж байгаа төлбөрт үйлчилгээний арга туршлага зэргийг судалж тэмдэглэл хөтлөн ажиллаж, цаашдын үйл ажиллагаанд нэвтрүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллахаар боллоо.